



Бизнестэй холбоотой төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах замаар Монгол улсад бизнесийн орчныг сайжруулах тухайд МҮХАҮТ-ын байр суурь

Танилцуулга

Төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд чухал алхам юм. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид төрийн байгууллагуудаас авдаг зөвшөөрөл, бүртгэл, лавлагаа зэрэг үйлчилгээний явцад олон шат дамжлага, тодорхой бус дүрэм журам мөрдөх, хугацаа алдах зэрэг хүнд сурталтай тулгарсаар байна. Энэ нь бизнес эрхлэх зардлыг нэмэгдүүлж, итгэлцлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлт, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) нь бизнесийн эрх ашгийг хамгаалах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, илүү өрсөлдөх чадвартай, таатай бизнесийн орчныг бүрдүүлэхийн төлөө тууштай ажилладаг байгууллага юм. МҮХАҮТ нь ОУХБ-тай хамтран 2024 онд "Хүнд суртлын индекс ба өртөг" судалгааг хийсэн ба Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 975 бизнес эрхлэгчид, тэр дундаа бичил, жижиг бизнес эрхлэгчдийг мөн хамруулав. Судалгаагаар төрийн үйлчилгээтэй холбоотой бизнес эрхлэгчдэд тулгарч буй сорилт, саад бэрхшээлийг тодорхойллоо.

Энэхүү баримт бичиг нь судалгааны гол үр дүнг танилцуулж, төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын зөвлөмжийг дэвшүүлж байна. Монгол улсад бизнес эрхлэхэд тулгардаг гол бэрхшээлийн нэг бол төрийн үйлчилгээний төвөгтэй, удаан, давхардсан үйл явц, мөн мэдээллийн ил тод бус байдал, бодлогын тогтворгүй орчин юм. 2024 оны "Хүнд суртлын индекс ба өртөг" судалгаагаар бизнесийн үйл ажиллагаатай холбоотой төрийн үйлчилгээний хүнд суртлын индекс 2.85 оноотой байгаа нь 2021 оны судалгаанаас бага зэрэг сайжирсан хэдий ч 2018 оны цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй хэвээр байна.

Хүнд суртлын индекс ба өртөг судалгааны дүнгээр 2021 оны үнэлгээтэй харьцуулахад Хүнд суртлын индекс сайжрах хандлагатай байна. Тодруулбал, үнэлгээний ерөнхий индексийн таван үзүүлэлтээс Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа, хандлага, төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо, төрийн байгууллагуудын ил тод байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал зэрэг дөрвөн үзүүлэлтэд эерэг өөрчлөлт ажиглагдсан. Мөн төрийн үйлчилгээг илүү нарийвчилсан түвшинд үнэлсэн албан хаагч, үйлчилгээний хугацаа, бүрдүүлэх баримт бичгийн тоо зэрэг үзүүлэлтүүд нь өмнөх онтой харьцуулахад сайжирсан дүнтэй байна.

Гэсэн хэдий ч судалгааны дүнгээр дараах асуудлууд шийдвэрлэгдээгүй, цаашид анхаарах шаардлагатай хэвээр байгааг харуулж байна. Үүнд:

- ▶ **Мэдээллийн хүртээмж, ойлгомжтой байдал буурсан:** Бизнес эрхлэгчид хууль, журамтай холбоотой шаардлагатай мэдээллийг бүрэн авч чадахгүй байгаагаас болж эрх зүйн зохицуулалтыг зөв ойлгож мөрдөхөд хүндрэл үүсэж байна.
- ▶ **Бизнесийн оролцоо хангалтгүй байна:** Хувийн хэвшил нь холбогдох хууль, бодлого боловсруулах үйл явцад оролцож, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийхэд Засгийн газартай хамтран ажиллах боломж хангалтгүй байдаг. Үүний улмаас хувийн хэвшил нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах боломжит хувь нэмрээ бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй нөхцөл бүрдэж байна.
- ▶ **Үйл явцын давхардал, цаг хугацааны алдагдал нь үр ашиггүй байдал үүсгэж байна :** Бизнес эрхлэгчид төрийн үйлчилгээ авахад дунджаар 12 хоног зарцуулдаг. Мөн судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 65 хувь нь ижил мэдээллийг олон төрийн байгууллагад давтан өгөх шаардлагатай болдог гэж гэжээ. Ийм давхардсан, үр ашиггүй үйл явц нь ялангуяа манай улсын нийт аж ахуйн нэгжийн ихэнхийг бүрдүүлдэг жижиг бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулж, бизнесийн үйл ажиллагаанд саад болдог.
- ▶ **Албан бус байдлыг өдөөж байна :** Бичил болон жижиг бизнес эрхлэгчид нь томоохон аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад төрийн үйлчилгээний хүртээмж муу, илүү их хүнд суртал, зохицуулалтын дарамтад өртдөг бөгөөд хууль, журамд нийцэж ажиллах чадамж нь хязгаарлагдмал байдаг. Бичиг цаасны шаардлага, зохицуулалт ихсэх тусам дүрэм, журмыг дагаж мөрдөх сонирхол буурдаг байна.

Эдгээр зохицуулалтын үр ашиггүй байдал нь хөрөнгө оруулалтыг саатуулж, бизнесийн өрсөлдөх чадварыг бууруулж, олон аж ахуйн нэгж албан системээс гадуур үйл ажиллагаа явуулахад хүргэж байна. Цаашлаад энэ нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж, татварын орлогыг хязгаарлан, төр хувийн хэвшлийн харилцан итгэлцлийг алдагдуулж байна.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ) нь төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах, зохицуулалтыг оновчтой болгох, хувийн хэвшлийн оролцоог бодлого боловсруулах шатанд бодитой нэмэгдүүлэх нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудад хувийн хэвшлийн хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх чухал алхмууд гэж үзэж байна.

2024 оны “Хүнд Суртлын Индекс ба Өртөг” судалгааны үр дүнгээс харахад, олон шатлалтай төрийн үйлчилгээний үйл явц, төрийн мэдээллийн ил тод бус байдал болон дүрэм журмын тогтвортой бус хэрэгжилт нь бизнесийн үйл ажиллагаанд томоохон хүндрэл үүсгэдэг. Эдгээр асуудлууд нь хөрөнгө оруулалтын идэвхийг бууруулж, үр ашгийг багасган, улсын өрсөлдөх чадварыг сулруулдаг.

МҮХАҮТ нь дараах гурван чиглэлд бодит арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Нэгдсэн, ойлгомжтой, уялдаа холбоотой төрийн үйлчилгээний зохицуулалт хийх

Нэг ижил баримт бичгийг олон дахин төрд давтан бүрдүүлдэг байдлыг шийдвэрлэх, мэдээллийн санг уялдуулах, үйлчилгээний шаардлагыг стандартчилах, үйл явцын оновчтой загварчлал хийх шаардлагатай. Судалгаагаар бизнесүүдийн 65% нь ижил мэдээллийг дахин өгөх шаардлагатай болдог ба нэг төрийн үйлчилгээ авахдаа дунджаар 12 хоног зарцуулдаг гэжээ.

2. Бизнесийн оролцоог бодлого боловсруулах шатанд нэмэгдүүлэх

Хууль, журам боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явцад бизнес эрхлэгчдийн идэвхтэй оролцоог хангах, институцийн түвшний тогтолцоог бий болгох шаардлагатай. Ийм оролцоо нь бодит хэрэгцээнд нийцсэн, чанартай бодлого боловсруулах, төр-хувийн хэвшлийн итгэлцлийг бэхжүүлэх, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

3. Бичил, жижиг бизнесүүдэд чиглэсэн хүнд суртлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх

Судалгааны дүнгээр бичил, жижиг бизнесүүд төрийн үйлчилгээ авахад хамгийн их хүндрэлтэй тулгардаг бөгөөд энэ нь бизнесээ тэлэх, албан зах зээлд нэвтрэх боломжийг хязгаарлаж байна. Үүнийг шийдвэрлэснээр эдийн засгийн тэгш хүртээмж нэмэгдүүлэх, албан бизнесийг өргөжүүлэх суурь нөхцөл болно.

МҮХАҮТ нь төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах, бизнес эрхлэх нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд :

1. Мэдээллийн ил тод, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх.

- Бизнесийн бодлого боловсруулах түвшинд бизнес эрхлэгчдийн бодит саналыг тусгадаг механизм бий болгох.
- Шинэчлэгдсэн холбогдох хууль, дүрэм, зохицуулалтын талаарх мэдээллийг төвлөрүүлсэн цахим сан байгуулах.
- Бодлогын өөрчлөлтийн талаарх мэдээллийг олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор тогтмол нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах.

2. Баримт бичиг, төрийн үйлчилгээний хугацааг багасгах.

- Аж ахуйн нэгж, иргэд төрийн үйлчилгээг хялбар авах нөхцөлийг бүрдүүлэх, нэг цонхны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Бизнес эрхлэгчид зөвшөөрсөн тохиолдолд өгсөн мэдээллийг төрийн агентлагууд хоорондоо хуваалцах боломжийг бүрдүүлж, мэдээллийг олон удаа давтан өгөх шаардлагыг бууруулах.
- Төрийн байгууллагууд нэгдсэн стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх, шаардлагагүй давхардсан бичиг баримтыг бууруулах зорилгоор төр-хувийн хэвшлийн хамтарсан үнэлгээ тогтмол хийх.

3. Цахим засаглалыг өргөжүүлэн, хөгжүүлэх.

- E-Mongolia, E-Business зэрэг платформуудын хүртээмж, хэрэглээний ойлгомжтой байдлыг сайжруулах.
- Тусгай зөвшөөрөл, татварын тайлан, бүртгэлийн шинэчлэлт зэрэг үйлчилгээг боломжит түвшинд цахимжуулах, процессыг хялбаршуулах.

4. Төрийн үйлчилгээний чанар, хариуцлагыг нэмэгдүүлэх.

- Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг хянах нэгдсэн систем бий болгож, хариуцлага тооцох тогтолцоо бүрдүүлэх.
- Төрийн үйлчилгээ үзүүлэгч албан хаагчдад зориулсан тогтмол сургалт, чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх, үйлчилгээний ач холбогдлыг танин мэдүүлэх, ёс зүй, ур чадварыг дээшлүүлэх.
- Төрийн худалдан авах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод, шударга оролцоог хангах зорилгоор үнэлгээний хорооны гишүүдийг санамсаргүйгээр сонгон шалгаруулах механизмыг нэвтрүүлэх.

5. Албан ёсны бизнесийн үйл ажиллагааг дэмжих.

- Бичил, жижиг бизнесүүдэд зориулсан тусгай татварын хөнгөлөлт, урамшууллын хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Хяналт шалгалт, торгуультай холбоотой маргааныг хараат бус, шударгаар шийдвэрлэх механизм бүрдүүлэх .

Төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах нь Монгол улсын бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн өсөлтийг дэмжих өндөр ач холбогдолтой алхам юм. МҮХАҮТ болон ОУХБ-ын хамтарсан судалгаа нь бизнес эрхлэгчдийн тулгамдаж буй гол саад бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх бодит зөвлөмжүүдийг боловсруулсан.

МҮХАҮТ нь төрийн үйлчилгээний ил тод байдал, цахимжуулалт, зохицуулалтын оновчлол, бизнесийн оролцоог нэмэгдүүлэх болон бичил, жижиг бизнесүүдэд чиглэсэн дэмжлэг зэрэг үндсэн чиглэлээр бодит өөрчлөлт хийхийг УИХ, Засгийн газар болон холбогдох байгууллагуудад уриалж байна.

МҮХАҮТ нь эдгээр өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил, олон улсын түншүүдтэй хамтран ажиллахад бүрэн бэлэн байгаа бөгөөд бизнесийн дуу хоолойг бодлого боловсруулах түвшинд хүргэхэд манлайлан ажиллах болно.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
2025 оны 5 сарын 6